



МОНГОЛ УЛС ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ ТОГТООЛ

2006 оны 1... дугаар
сарын 11...-ны өдөр

Дугаар 6.

Улаанбаатар
хот

**“БиДиСек” ХХК-иас ХК болон өөрчлөгдөж
шинээр гаргах хувьцааг бүртгүүлэх
хүсэлтийн тухай**

“Иргэний хууль”-ийн 31 дүгээр зүйл, “Компанийн тухай” хуулийн 18, 23 дугаар зүйл, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 4, 5, 6, 7-р зүйл болон 34-ийн 1-ийн 7 дахь заалт, “БиДиСек” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2005.12.01-ний хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “БиДиСек” ХХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн хувьцаат компаниар бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Тус компаниас гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10 сая ширхэг хувьцааг үнэт цааст тооцож, 7500000 ширхгийг нийтэд санал болгон худалдах, 2500000 ширхгийг “БиДиСек” ХК-д хаалттай эзэмшүүлэхээр үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл, Хөрөнгийн биржийн жагсаалт болон “ҮЦТТТХТ” ХХК-ийн бүртгэлд тус тус бүртгэхийг Ажлын алба/Ж.Жадамбаа/, Хөрөнгийн бирж ХК/Р.Содхүү/, “ҮЦТТТХТ” ХХК/Н.Туяацэцэг/-д зөвшөөрсүгэй.


3. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг компанийн удирдлага/Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг БСХОХ/Б.Аюуш/-т даалгасугай.



С.ГҮНДЭНБАЛ

Ж.ЖАДАМБАА



5.ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

1. Орлого

Компанийн орлогын багц дараахь байдалтай байна:

- Брокерийн үйл ажиллагааны орлого:
 - Хувьцааны арилжааны шимтгэл
 - Засгийн газрын бондын арилжааны шимтгэл
 - Компанийн бондын арилжааны шимтгэл
 - Бусад үйлчилгээний хөлс, хураамж
- Дилерийн үйл ажиллагааны орлого:
 - Бондын хүү
 - Хувьцааны ноогдол ашиг
 - Үнэт цаасны ханшийн өсөлт
- Андеррайтерын үйл ажиллагааны орлого
 - Шинээр үнэт цаас гаргахад зуучлах
 - Шинэ үнэт цаасанд андеррайтер хийх

Орлогын төлөвлөгөө / төгрөгөөр /

Д.д	Орлогын нэр		2006 он	2007 он	2008 он
1	Брокерийн үйл ажиллагаа	Хувьцааны арилжааны шимтгэл	10,000,000	20,000,000	60,000,000
		Засгийн газрын бондын арилжааны шимтгэл	8,600,000	10,750,000	16,125,000
		Компанийн бондын арилжааны шимтгэл	1,500,000	3,000,000	5,250,000
		Бусад үйлчилгээний хөлс, хураамж	1,000,000	1,200,000	1,500,000
2	Дилерийн үйл ажиллагаа	Бондын хүү	129,600,000	155,520,000	186,624,000
		Хувьцааны ноогдол ашиг ба Үнэт цаасны ханшийн өсөлт	45,000,000	49,500,000	54,450,000
		Үнэт цаас гаргахад зуучлах, андеррайтер хийх	45,000,000	90,000,000	135,000,000
3	Андеррайтерын үйл ажиллагаа				
4	Нийт		240,700,000	329,970,000	458,949,000

БҮРТГЭВ | 02
 Бүртгэл хяналтын
 Алба

Орлогын төлөвлөгөөний задаргаа

1 Брокерийн үйл ажиллагаа

а. Компанийн хувьцааны арилжаа

Он	Гүйлгээний хэмжээ	Шимтгэл / хувиар /	Шимтгэлийн дүн
2006	500,000,000	2	10,000,000
2007	1,000,000,000	2	20,000,000
2008	3,000,000,000	2	60,000,000

б. Засгийн газрын бондын арилжаа

Он	Гүйлгээний хэмжээ	Шимтгэл / хувиар /	Шимтгэлийн дүн
2006	8,000,000,000	0.11	8,600,000
2007	10,000,000,000	0.11	10,750,000
2008	15,000,000,000	0.11	16,125,000

в. Компанийн бондын арилжаа


Он	Гүйлгээний хэмжээ	Шимтгэл / хувиар /	Шимтгэлийн дүн
2006	1,000,000,000	0.15	1,500,000
2007	2,000,000,000	0.15	3,000,000
2008	3,500,000,000	0.15	5,250,000

Нийт брокерийн үйл ажиллагааны орлого

Он	Орлогын хэмжээ
2006 он	20,100,000
2007 он	33,750,000
2008 он	81,375,000

Тайлбар:

Брокерийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь компанийн өмнөх онуудын үйл ажиллагааны дүнд үндэслэсэн бөгөөд хөрөнгийн зах зээлийн хэтийн төлөв, компанийн өөрийн хөрөнгийн өсөлт нь нийт гүйлгээний дүнд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй юм. Компани нь 2004 онд МХБ-ийн нийт гүйлгээний дүнгийн 30 орчим хувийг дангаар хийж байсан ба 2005 онд компанийн хийсэн нийт гүйлгээний дүн өмнөх оноос 3 дахин /ойролцоогоор/ өссөн байна. Компанид хөрөнгө оруулалт орж эргэлтийн хөрөнгө өссөнөөр улам илүү арилжаа хийх боломжтой.



2 Дилерийн үйл ажиллагаа

Компани өөрийн портфолиоог бүрдүүлэхдээ нийт хөрөнгийн 66 хувийг компанийн бондоор, 33 хувийг компанийн хувьцаагаар бүрдүүлэх төлөвлөгөөтэй байна.

Компанийн бонд

Зах зээл дээр компанийн бондын хүүгийн түвшин 1,8% байгаа бөгөөд 2005 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар "Пума бонд" 500 сая, "Бүтээн байгуулалт" бонд 100 сая төгрөгийн үлдэгдэл зах зээл дээр байгаа юм.

Он	Бондын хэмжээ / төгрөгөөр /	Хүү / хувиар /	Хүүгийн дүн
2006	-	1,8%	-
2007	-	1,8%	-
2008	-	1,8%	-

Компанийн хувьцаа

Компанийн хувьцаа хэлбэрээр оруулах хөрөнгө оруулалт нь компанийн портфолиогийн 33 хувийг эзлэх бөгөөд татварын өмнөх ашгийн түвшин ханшийн зөрүү болон ноогдол ашгийг оролцуулан жилийн 15 хувь байхаар тооцооллоо.

Он	Хувьцааны хэмжээ / төгрөгөөр /	Хүү / хувиар /	Хүүгийн дүн
2006	300,000,000	15	45,000,000
2007	330,000,000	15	49,500,000
2008	363,000,000	15	54,450,000

Нийт дилерийн үйл ажиллагааны орлого

Он	Орлогын хэмжээ
2006 он	45,000,000
2007 он	49,500,000
2008 он	54,450,000

3 Андеррайтерын үйл ажиллагаа

Компаниудын шинээр гаргаж буй үнэт цаасанд андеррайтер хийх нь компанийн үйл ажиллагааны нэгэн үндсэн чиглэл бөгөөд 2004 оноос энэ үйл ажиллагаа улам идэвхижих хандлагатай байна.

Одоогоор компанийн зүгээс зарим нэгэн бондод явуулж буй зуучлалын үйл ажиллагаанаас гадна 2006 онд гаргахаар төлөвлөж буй үнэт цаас /бонд болон энгийн хувьцаа/ -нд андеррайтераар ажиллахаар урьдчилсан байдлаар хэлэлцэж буй 2-3 компани байгаа болно.

Өнөөдрийн байдлаар хөрөнгийн зах зээл дээр андеррайтер болон брокер, дилерийн үйлчилгээг цогцоор үзүүлж буй аж ахуйн нэгж "БиДиСек"ХХК-аас өөр байхгүй байгаа юм.

Он	Шинээр зуучлах үнэтХ цаасны хэмжээ	Шимтгэл / хувиар /	Орлогын дүн
2006	3,000,000,000	1.5	45,000,000
2007	6,000,000,000	1.5	90,000,000
2008	9,000,000,000	1.5	135,000,000

КОМПАНИД ОРОХ НИЙТ ОРЛОГЫН ХЭМЖЭЭ /ОНООР/ / брокер, дилер, андеррайтерын үйл ажиллагаа /

Он	Орлогын хэмжээ / төгрөгөөр /
2006 он	240,700,000
2007 он	329,970,000
2008 он	458,949,000

БҮРТГЭВ | 02
Бүртгэл хяналтын
Алба

2. Зарлага

Компанийн зарлага дараахь бүтэцтэй байна:

- Үйл ажиллагааны зардал
- Ханшийн уналтын болзошгүй алдагдал

Үйл ажиллагааны зардал нь компанийн хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэхэд гарах зардал бөгөөд дотроо:

- Тогтмол зардал
- Хувьсах зардал гэж хуваагдана.

Компанийн зардлын төлөвлөгөө:

Д.д	Зардал		2006 он	2007 он	2008 он
1	Тогтмол	Байрны түрээс	4,800,000	4,800,000	5,200,000
		МХБ-ийн гишүүний хураамж	700,000	770,000	850,000
2	Хувьсах	Цалин	36,600,000	36,600,000	40,260,000
		Оффисын	1,200,000	1,350,000	1,500,000
		Маркетингийн	3,600,000	4,800,000	6,000,000
		Холбоо харилцааны	3,600,000	4,000,000	4,500,000
		Унааны	1,200,000	1,200,000	1,500,000
		Бусад	1,200,000	1,200,000	1,500,000
		НДШ-ийн	6,950,000	6,950,000	7,650,000
		Удирдлагын зардал	2,400,000	2,400,000	2,600,000
Нийт		62,250,000	64,070,000	71,560,000	

3. Ашиг /төгрөгөөр/


Он	2006	2007	2008
Орлого	240,700,000	329,970,000	458,949,000
Зардал	62,250,000	64,070,000	71,560,000
Ашиг	178,450,000	265,900,000	387,389,000
Орлогын татвар	26,767,500	39,885,000	58,108,350
Цэвэр ашиг	151,682,500	226,015,000	329,280,650

БҮРТГЭВ 02
Бүртгэл хяналтын
Алба 11

НООГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Компани нь хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулах анхны хувийн хувьцаат компани болохын хувьд хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж, бусад хувьцаат компаниудад жишээ болохуйц шинэ арга барилаар ажиллах бөгөөд хувьцаат компанийн үйл ажиллагааны дэлхий нийтийн хэм хэмжээг чанд баримтлан, хөрөнгө оруулагчдыг урамшуулах, компанийн хувьцааны ханшийг өсгөснөөр компанийн үнэ цэнийг дээшлүүлэх бодлого баримталж ажиллана.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу ноогдол ашиг хуваарилах эцсийн шийдийг Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргах боловч энэ хэмжээг жилийн цэвэр ашгийн 40 хувиас багагүй түвшинд байлгах бодлого баримтлах бөгөөд энэ нь нэгж хувьцаанд ноогдох ноогдол ашиг нь хувьцааны үнийн 5-15 хувиас багагүй байх тооцоо гарч байгаа юм.





“БиДиСЕК” Хувьцаат компани

“БиДиСЕК”ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн, Арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн бөгөөд үнэт цаасны зах зээлд тасралтгүй 15 жил ажиллаж буй тэргүүлэгч компани юм. 2005 оноос Үнэт цаасны зах зээл дээр андеррайтерын үйл ажиллагаа явуулах эрх авч, Брокер, Дилер, Андеррайтерын үйл ажиллагааг үзүүлж иж бүрнээр нь үзүүлж байна.


“БиДиСЕК”ХК нь харилцагчдаа дээдлэн, тэдний сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхээр чармайн ажилласны дүнд 2006 онд хөрөнгийн зах зээлд хийгдсэн нийт арилжааны 65 хувь буюу 11 тэрбум төгрөгийн арилжааг дангаар хийсэн нь өмнөх оныхоос 5 дахин өссөн байна.

Манай компани андеррайтер, брокер, дилерийн үйл ажиллагааг цогцоор нь явуулдаг Монгол Улсын цорын ганц компанийн хувьд өнгөрсөн онд нийт 3 шинэ хувьцаат компанийн 11,8 тэрбум төгрөгийн хувьцаа, 2 компанийн 1 тэрбум төгрөгийн компанийн бондыг зах зээлд амжилттай гаргаснаас 6,8 тэрбум төгрөгийн хувьцаа, 900 сая төгрөгийн бондыг анхдагч зах зээлд арилжиж дуусаад байна.

Ингэснээр 2006 онд манай компаниар дамжин зөвхөн анхдагч зах зээлд 7,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг үндэсний компаниудад оруулаад байна.

Санхүүгийн тайлан тэнцэл

Балансын зүйл	2005 он	2006 он
А.Хөрөнгө		
1.Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19,764,090.45	293,136,884.31
Богино хугацаат хөрөнгө оруулалт	105,172,284.00	528,359,320.00
Авлага	105,622,607.96	204,177,601.96
Бараа материал	227,700.00	227,700.00
Эрдлийн сан		(6,455,422.00)
Эргэлтийн хөрөнгийн дүн	230,786,682.41	1,019,446,084.27
2.Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	59,135,040.00	77,674,948.00
Хуримтлагдсан элэгдэл	(7,290,080.00)	(13,879,702.52)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	1,888,889.00	1,888,889.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	53,733,849.00	65,684,134.48
Нийт хөрөнгийн дүн	284,520,531.41	1,085,130,218.75
Б. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
3.Богино хугацаат өр төлбөр		
Өглөг	1,030,000.00	90,000.00
ХАОАТ-ын өглөг	39,000.00	
ААНОАТ-ын өглөг	947,196.93	5,291,600.00
НДШ-ийн өглөг		
Урьдчилж орсон орлого	20,000,000.00	20,000,000.00
Бусад өглөг		




Богино хугацаат өр төлбөрийн дүн	22,016,196.93	25,381,600.00
Урт хугацаат өр төлбөр		
Өр төлбөрийн нийт дүн	22,016,196.93	25,381,600.00
4.Эзэмшигчдийн өмч		
өмч		
а. Төрийн		
б. Хувийн	250,000,000.00	1,000,000,000.00
Нэмж төлөгдсөн капитал		100.00
Өмчийн дүн	250,000,000.00	1,000,000,100.00
Хуримтлагдсан ашиг: Тайлангийн үеийн	14,595,376.00	47,244,183.93
Өмнөх үеийн	(2,091,041.18)	12,504,334.82
Эзэмшигчдийн өмчийн дүн	262,504,334.82	1,059,748,618.75
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	284,520,531.75	1,085,130,218.75

Балансын зүйл	2005 он	2006 он
1.Үндсэн үйл ажиллагааны орлого		
Цэвэр борлуулалт	46,324,048.98	173,278,831.57
Борлуулалтын орлогын дүн	46,324,048.98	173,278,831.57
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3.Нийт ашиг /алдагдал/	46,324,048.98	173,278,831.57
4.Үйл ажиллагааны зардал	28,728,072.98	107,163,873.73
5.Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	17,595,976.00	66,114,957.84
6.Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/	361,200.00	8,805,273.91
7.Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	17,234,776.00	57,309,683.93
Орлогын татварын зардал	2,639,400.00	10,065,500.00
8.Татварын дараах ашиг /алдагдал/	14,595,376.00	47,244,183.93
9.Ердийн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	14,595,376.00	47,244,183.93
Онцгой шинжтэй зарлага		
10.Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	14,595,376.00	47,244,183.93

1. Ногдол ашиг хуваарилах тухай

Тус компани 2006 онд 47 224 183,93 төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд нэгж хувьцаанд 3 төгрөг буюу 10 000 000 ширхэг хувьцаанд нийт 30 000 000 төгрөгийг хуваарилахаар ТУЗ-аас шийдвэрлэсэн болно. Ногдол ашгийг Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв дахь дансанд байршуулна.



2.2007 оны төлөвлөгөө

Манай компани 2007 оныг “Үндэсний томоохон хэмжээний үйлдвэрлэл, аж ахуй нэгж, компаниудыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын тэргүүлэх салбарууд болох уул уурхай, санхүү, аялал жуулчлал болон хөнгөн үйлдвэрийн салбарын томоохон компаниудад хөрөнгө оруулалт хийнэ.

- Шинээр байгуулагдаж буй томоохон үйлдвэрүүдэд андеррайт хийх
- Гадаадын хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлд оролцоход зуучлах
- 500,0 сая төгрөгөөс дээш санхүүжилттэй төсөлд хөрөнгө оруулалт хийх
- Уул уурхайд ашигласан тосыг дахин боловсруулах үйлдвэрийн төслүүдийг эхний ээлжинд хэрэгжүүлэх
- Үнэт цаасны зах зээлд оролцох сонирхолтой аж ахуй нэгжтэй бүх талаар хамтран ажиллах
- Шинээр залуу боловсон хүчин дадлагажуулж авах
- Хувьцаат компаниудын мэдээллийн санг бий болгох
- Олон улсын мэрэгжилтэн урьж авчран тодорхой хугацаанд ажиллуулах

